

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 22-Р ХОРООНЫ  
НУТАГ ДЭВСГЭРТ БОГДХАН УУЛЫН ДЦГ-ЫН ЗАЙСАНГИЙН  
АМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ Ш. ЧИМЭДДОРЖИЙН “ХӨХ  
МОРЬТОН - УРАН БАРИМЛЫН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР  
2025

## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

|                                                                                                                                     |           |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>                                                                                             | <b>3</b>  |
| 1.1. Төслийн нэр .....                                                                                                              | 3         |
| 1.2. Төсөл хэрэгжүүлэгч .....                                                                                                       | 3         |
| 1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа .....                                                                                      | 3         |
| 1.1. Үйлчилгээний төв байгууламжийн төлөвлөлт .....                                                                                 | 4         |
| 1.2. Төслийн хүчин чадал .....                                                                                                      | 4         |
| 1.4. Төслийн байршил .....                                                                                                          | 5         |
| 1.3. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил .....                                                                                       | 5         |
| <b>2. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ .....</b>                                                                                      | <b>7</b>  |
| <b>3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....</b>                                                                    | <b>9</b>  |
| 3.1.1. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл .....                                                                                       | 9         |
| 3.2. Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлох .....                                                                                 | 9         |
| <b>4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ<br/>ЗОРИЛГО .....</b>                                                            | <b>12</b> |
| 4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө .....                                                                                      | 12        |
| 4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....                                                                    | 13        |
| 4.1.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө .....                                                              | 13        |
| 4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....                                                       | 13        |
| 4.1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....                                                                 | 13        |
| 4.1.5. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....                                                                                      | 13        |
| 4.2. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....                                                                               | 13        |
| <b>5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br/>ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>                                                            | <b>15</b> |
| <b>6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>                                                                       | <b>16</b> |
| <b>7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>                                                                                | <b>17</b> |
| <b>8. ОСОЛ, ЭРСДЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>                                                                                            | <b>18</b> |
| <b>9. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ<br/>ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>                                                         | <b>19</b> |
| <b>10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....</b>                                                                                 | <b>20</b> |
| <b>11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>                      | <b>22</b> |
| <b>12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ<br/>ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b> | <b>23</b> |
| <b>13. ДҮГНЭЛТ .....</b>                                                                                                            | <b>24</b> |

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

|                                                                          |    |
|--------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1. Ажиллах хүчний төлөвлөлт .....                                | 4  |
| Хүснэгт 2. Ажиллах хүчний төлөвлөлт .....                                | 4  |
| Хүснэгт 3. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ ..... | 9  |
| Хүснэгт 4. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр.....                          | 10 |

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

|                                                                          |    |
|--------------------------------------------------------------------------|----|
| Зураг 1. Төслийн талбайн барилга байгууламжийн төлөвлөлтийн шийдэл ..... | 3  |
| Зураг 3. Төслийн талбайн байршил .....                                   | 5  |
| Зураг 4. Төслийн орчны төлөв байдлын зураг .....                         | 5  |
| Зураг 5. Төслийн талбай орчмын налуужилтын зураг .....                   | 7  |
| Зураг 6. Төсөл хэрэгжих талбай орчмын гадаргын өндөржилт .....           | 8  |
| Зураг 7. Орчны хяналт шинжилгээ хийх цэгийн байршил .....                | 14 |

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн нэр

Хөх морьтон - уран баримлын цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын цогцолбор” төсөл

### 1.2. Төсөл хэрэгжүүлэгч

- Төсөл хэрэгжүүлэгч: Ш. Чимэддорж
- Регистрийн дугаар: ХБ54083075
- Холбоо барих утас: 88000551

### 1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа

“Хөх морьтон” уран баримлын цэцэрлэгт хүрээлэн нь “Морьтон” төвийн дэргэд байгуулагдах бөгөөд тус төв нь ардын зураач (Төрийн Соёрхолт, УГЗ) Ш.Чимэддоржийн санаачилга дор хэрэгжиж буй төсөл бөгөөд гадаад, дотоодын уран бүтээлчидтэй урлагийн олон төслүүд дээр хамтран ажилласан арвин их туршлага, өргөн харилцаа холбоо бүхий уран бүтээлч хүн юм. “Морьтон” дүрслэх урлагийн төв нь монголын дүрслэх урлагийн салбарын хөгжлийг дэмжих, энэ хүрээнд хувийн хэвшлийн зүгээс гаргаж буй идэвх чармайлтыг нэмэгдүүлэх, нэгтгэх зорилгоор байгуулагдаж буй төв юм. Тус төвийн үйл ажиллагаа нь дүрслэх урлагийн салбарын уран бүтээлчдийг дэмжих, үнэт бүтээлүүдийг эх орондоо авч үлдэх, шинээр түүх соёлын өв бүтээх, аялал жуулчлалын салбарыг дэмжих томоохон хэмжээний урлагийн бүтээлүүдийг бий болгоход чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг санаачлан, хэрэгжүүлэх чиглэлээр явагдана. “Хөх Морьтон” уран баримлын цэцэрлэгт хүрээлэн нь нийт 1.5 га талбайд байгуулагдах бөгөөд дараах 3 үндсэн хэсгээс бүрдэнэ:

**Монгол морьд** - Энэ хэсэгт Монгол адууг магтан, алдаршуулах зорилго бүхий морины сэдэвтэй баримлууд байрлана. Нийт 5-6 тооны баримал байрлуулах бөгөөд том хэмжээний буюу 3-15 метр орчим өндөртэй 1-2 баримал хийгдэнэ. Бусад баримлууд нь жижиг хэмжээтэй байна.

**Эрх чөлөөний тунхаглал** - Энэ хэсэгт эрх чөлөө, түүний үнэ цэнэ, ач холбогдлыг илэрхийлсэн утга, агуулга бүхий баримлууд байрлана. Голцуу гадаадын уран бүтээлчдийн баримал байршуулах бөгөөд 1ш том хэмжээтэй буюу 3-15 метр өндөр, бусад нь жижиг хэмжээтэй 4-5 ширхэг баримал байршина.

**Нүүдэлчид** - Энэ хэсэгт нүүдэлчдийн өв соёл, ахуй амьдралыг харуулсан танин мэдэхүйн чиглэлтэй баримлууд байрлана. Жижиг хэмжээний баримал 5-10 ширхэг баримал, сийлбэртэй монгол гэрүүд, Бүх хэсэгт баримлуудыг тойрсон зам талбай, үйлчилгээний цэг, ногоон байгууламжтай байх бөгөөд зам талдаа нийт 30-50 автомашины зогсоолтой байна.



Зураг 1. Төслийн талбайн барилга байгууламжийн төлөвлөлтийн шийдэл

**1.1. Үйлчилгээний төв байгууламжийн төлөвлөлт**

"Хөх Морьтон уран баримлын цэцэрлэгт хүрээлэн"-гийн гол бүтээн байгуулалт нь "Морьтон –Урлагийн Музей"-н барилга байна. Тус барилгад дараах чиглэлийн үйлчилгээ үзүүлнэ.

Хүснэгт 1. Ажиллах хүчний төлөвлөлт

| №    | Чиглэл                                  | м²   | Тайлбар                                                                                                                                                                                |
|------|-----------------------------------------|------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1    | Музей                                   | 800  | Монголын дүрслэх урлагийн салбарын гол төлөөлөгчдийн уран бүтээлийг монголдоо авч үлдэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор тогтмол үзмэр бүхий музей байнгын үйл ажиллагаа явуулна. |
| 2    | Галерей                                 | 300  | Гадаад, дотоодын уран бүтээлчдийн үзэсгэлэн тогтмол зохион байгуулна.                                                                                                                  |
| 3    | Дижитал галерей                         | 100  | Монголын болон дэлхийн урлагийн түүхийг харуулсан үзмэрүүд бүхий дижитал үзмэр, контент бүхий танхимууд үйл ажиллагаа явуулна.                                                         |
| 4    | Арт клуб                                | 300  | Уран зураг, керамик урлал, баримал, график дизайн зэрэг дүрслэх урлагийн төрлүүдээр клуб, дугуйлангууд ажиллана.                                                                       |
| 5    | Баримлын студи                          | 400  | Томоохон хэмжээний баримал бүтээх боломжтой хөнгөн хийцийн байгууламж                                                                                                                  |
| 6    | Арт шоп                                 | 300  | Бэлэг дурсгалын худалдаа                                                                                                                                                               |
| 7    | Галерей-Ресторан                        | 500  | Ресторан ажиллана.                                                                                                                                                                     |
| 8    | Кофе шоп                                | 100  | Үүдний хэсэгт байрлана.                                                                                                                                                                |
| 9    | Үйлчилгээтэй сууц буюу түр отоглох байр | 500  | Гадаадын хүндтэй зочдод зориулсан үйлчилгээтэй сууц 2 ширхэг төлөвлөгдсөн                                                                                                              |
| Нийт |                                         | 3300 |                                                                                                                                                                                        |

**1.2. Төслийн хүчин чадал**


"Хөх морьтон" төслийн үйлчилгээний төвөөр хоногт 100 хүн, амрагчдын отголох сууцанд 50 хүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд нийт 20 хүн байнгын ажлын байраар хангагдахаар төсөлд тусгасан байна. Жилийн 4 улирал тасралтгүй үйл ажиллагаа явуулна.

Хүснэгт 2. Ажиллах хүчний төлөвлөлт


| №    | Чиглэл                                                    | Ажилчдын тоо | Тайлбар                                                                                             |
|------|-----------------------------------------------------------|--------------|-----------------------------------------------------------------------------------------------------|
| 1    | Музей, галерей                                            | 1            | Куратор-зохион байгуулагч                                                                           |
| 2    | Арт клуб                                                  | 3            | Уран баримал-Керамик, уран зураг, дижитал артграфик дизайн гэсэн чиглэлүүдээр тус бүр 1 багш байна. |
| 3    | Урлан, Зочид буудал, үйлчилгээтэй орон сууц, фитнес, саун | 3            | Менежер, ресепшин, үйлчлэгч                                                                         |
| 4    | Ресторан                                                  | 6            | Менежер, тогооч-2, бармен, зөөгч – 2                                                                |
| 5    | Харуул хамгаалалт                                         | 3            | Хамгаалагч (цахилгаан, сантехник хариуцсан ажилтан)                                                 |
| 6    | Захиргаа                                                  | 4            | Захирал, ерөнхий менежер, нягтлан бодогч, нярав-үйлчлэгч                                            |
| Нийт |                                                           | 20           |                                                                                                     |

#### 1.4. Төслийн байршил

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэр, Богдхан уулын ДЦГ-ын Зайсангийн аманд, 1.5 га талбайд хэрэгжиж байна.



Зураг 2. Төслийн талбайн байршил



Зураг 3. Төслийн орчны төлөв байдлын зураг

#### 1.3. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Төслийн талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэрт байрлах тул зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, цахилгаан хангамж зэрэг дэд бүтэц сайн хөгжсөн.

**Цахилгаан хангамж:** Төсөл хэрэгжих орчин нь нийслэлийн хүн амын суурьшлын бүсэд орших бөгөөд төвийн цахилгаан хангамжид холбогдохоор төсөлд тусгасан байна.

**Цэвэр усны хангамж:** Төсөл нь өөрийн эзэмшил талбайд байрлах гүний худгаас унд ахуйн хэрэглээний усыг хангана.

**Харилцаа холбоо:** Үүрэн холбооны бүх операторууд болон интернэтийн сүлжээг ашиглах боломжтой.

**Дулаан хангамж:** Дулаан хангамжийг Төвийн нэгдсэн дулааны болон бохир ус татан зайлуулах шугамд холбогдохоор төлөвлөсөн байна. Төвийн нэгдсэн дулаан болон бохир ус зайлуулах сувагт холбох хугацаанд цахилгаан халаалтын систем ашиглан дулааны асуудлыг шийдвэрлэнэ.

**Зам харилцаа:** Зам харилцаа сайн хөгжсөн орчинд байрлах бөгөөд хотын төв Сүхбаатарын талбайгаас урагш 6 км орчим, Зайсан виллагаас 730 орчим метр зайтай бөгөөд хатуу хучилттай замаас төслийн талбай хүртэл 20 м орчим шороон замаар явж хүрнэ.




## 2. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

Төсөл нь Монгол улсын байгалийн бүс, бүслүүрийн онцлогоор уулын тайга, уулын ойт хээрийн бүсэд багтдаг ба засаг захиргааны хуваариар Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 22-р хорооны нутаг дэвсгэр, Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байрлана.


Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн уулсын баруун өмнөд шувтрах үзүүрт Богдхан уулын ард, Туул голын өргөн хөндий ба түүний цутгал голуудаар хэрчигдсэн хэсэгт оршино. Туулын дэнж хотын зүүн хэсэгт нарийн 2.5-3.0 км орчим өргөн, баруун тийш болох тутам өргөсөн хотын баруун талд 5.0-5.5 км орчим өргөн болох ба ерөнхийдөө зүүнээсээ баруун тийшлэх тусмаа намсана. Хотын эргэн тойронд Богдхан уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй уулс хүрээлнэ. Дархан цаазат Богдхан уул нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд захад орших дундаж өндөртэй уул юм.

Байрлалын хувьд Хэнтийн гол нуруунаас саланги тусгаар орших боловч өндрийн нөлөөгөөр тэнд ой, тайгын ландшафт голлох байр эзлэх бөгөөд манай орны ойт хээр, хээр, хуурай хээрийн бүсийн зааг дээр орших өвөрмөц бүтэцтэй ландшафтын хувьд босоо бүслүүр илрэх уулсын систем юм. Богдхан уулын гол нуруу нь өргөргийн дагуу буюу баруунаас зүүн тийш сунаж тогтсон байх ба энд ихэвчлэн 000 м, түүнээс дээш өргөгдсөн тэгшрэлийн гадарга бүхий хавтгай, бөмбөгөр оройтой оргилууд зонхилно. Хамгийн өндөр оргил нь 2268 м үнэмлэхүй өндөртэй Цэцээ гүн бөгөөд түүний харьцах өндөр нь 900-1000 м болно. Мөн энд Түшээ гүн (2256.0 м), Их, Бага Тэнгэрийн нуруу (2094.0 м), Зүүн Ширээт (2150.0 м), Баруун Ширээт (2004.0 м) зэрэг өндөр оргилууд бий. Эдэлбэр газрын налуу нь 2.8-36.6° налуутай байгаа бол өндөршил нь далайн түвшнээс дээш 1385-1388 м байрлах бөгөөд баруунаас зүүн чиглэлд өндөршиж байна



Зураг 4. Төслийн талбай орчмын налуужилтын зураг





Зураг 5. Төсөл хэрэгжих талбай орчмын гадаргын өндөржилт

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Хан-уул дүүргийн 22-р хороо, Богдхан уулын ДЦГ-ын тусгай хамгаалалттай газар нутагт Иргэн Ш. Чимэддоржийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Хөх морьтон - уран баримлын цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын цогцолбор” төслийн танилцуулга болон бусад холбогдох бичиг баримтыг нарийвчлан судалж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын дагуу дараах аргачлалд заасан нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлох “Магадлан жагсаах” (checklist), болон “Леопольдын матрицын арга”, нөлөөлөл буурах функц ArcGIS 10.3 программын “MDT” түүлс ашиглан тодорхойлов. Дээрх сөрөг нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр үйлдвэрийн технологийн болон үйл ажиллагааны менежментийн хувьд хэрэгжүүлэх боломжтой шийдэл зөвлөмжийг боловсруулсан болно.

#### 3.1.1. Байгаль орчны үнэлгээний нэгтгэл

Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн 22-р хороо Богдхан Уулын дархан цаазат газар Зайсангийн аманд хэрэгжиж буй Ш. Чимэддоржийн “Хөх морьтон - уран баримлын цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын цогцолбор” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх хэсэгт авч үзсэнийг нэгтгэвэл 26 үзүүлэлтээр нөлөөллийн эрчмийг тодорхойлсноос байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн нөлөөллийн 16.0% нь нөлөөлөлгүй, 44% нь бага, 36% нь дунд, 4.0% их байна. Агаарын чанар, эдэлбэр газар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим байгаль орчны бусад бүрдэл хэсгүүдээс их байна.

Хүснэгт 3. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрчим, түүний үнэлгээ

| №                | Байгаль орчны бүрдэл хэсгүүд                    | Сөрөг нөлөөллийн эрчмийн зэрэг |      |      |    |          | Үнэлгээ |       |
|------------------|-------------------------------------------------|--------------------------------|------|------|----|----------|---------|-------|
|                  |                                                 | Нөлөөгүй                       | Бага | Дунд | Их | Сүйрлийн | Тоо     | Хувь  |
| 1                | Эдэлбэр газарт үзүүлэх нөлөө                    | 2                              | 1    | 1    | 0  | 0        | 4       | 16    |
| 2                | Агаарын чанарт үзүүлэх нөлөө                    | 0                              | 2    | 3    | 0  | 0        | 5       | 24    |
| 3                | Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөө | 2                              | 2    | 0    | 0  | 0        | 4       | 16    |
| 4                | Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө                  | 0                              | 4    | 2    | 1  | 0        | 7       | 24    |
| 5                | Ургамал, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөө         | 0                              | 1    | 1    | 0  | 0        | 2       | 8     |
| 6                | Амьтны аймагт үзүүлэх нөлөө                     | 0                              | 1    | 2    | 0  | 0        | 3       | 12    |
| Нөлөөллийн эрчим |                                                 | 4                              | 11   | 9    | 1  | 0.0      | 25      | 100.0 |
|                  |                                                 | 16%                            | 44%  | 36%  | 4% | 0.0      |         |       |

#### 3.2. Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлох

Ш. Чимэддоржийн “Хөх морьтон - уран баримлын цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын цогцолбор” төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв.

Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл жуулчны баазын төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

1. Ахуйн шингэн хаягдлыг зайлуулах технологийн горимыг баримтлаагүй тохиолдолд газрын гүний болон хөрсний ус бохирдож улмаар гадаргын усны чанарт сөргөөр нөлөөлөх.
2. Хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах журам, дэглэм, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хөрс болон агаар орчныг бохирдуулах.
3. Машин тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн ихсэх, олон салаа зам гаргах зэргээс хөрс элэгдэл эвдрэлд орох, дагтарших.
4. Хүний хөдөлгөөн ихсэх, түр хугацааны жим, зам гарах, анхаарал болгоомжгүйгээс ой хээрийн түймэр гарах зэрэг нь ургамлан бүрхүүлд нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж /хогийн ургамал ихсэх/, ургац муудах магадлалтай.
5. Жуулчны баазын дуу чимээний нөлөөллөөс шалтгаалан ойр орчмын амьтад дайжиж болно.

## Хүснэгт 4. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

| №                      | Нөлөөлөл                   | Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)                                                                                          | Нөлөөллийн шинж чанар                                                                                                                                                        |
|------------------------|----------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <i>Агаар орчин</i>     |                            |                                                                                                                               |                                                                                                                                                                              |
| 1                      | Тоосжилт                   | - Хүмүүсийн хөл<br>- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн                                                                            | - Улирлын чанартай.<br>- Тархах хүрээ хязгаарлагдмал.                                                                                                                        |
| 2                      | Утаа, хийн хаягдал         | - Тээврийн хэрэгсэл                                                                                                           | - Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал.                                                                                                  |
| <i>Усан орчин</i>      |                            |                                                                                                                               |                                                                                                                                                                              |
| 3                      | Хатуу болон шингэн хаягдал | - Ахуйн хог хаягдал<br>- Шатах тослох материалын хаягдал                                                                      | - Гадаргын ус бохирдоно.<br>- Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай.                                                                                                    |
| 4                      | Усны нөөцийн хомсдол       | - Унд ахуйн усны хэрэглээ                                                                                                     | - Шууд бус дам нөлөө үзүүлнэ                                                                                                                                                 |
| <i>Хөрсөн бүрхэвч</i>  |                            |                                                                                                                               |                                                                                                                                                                              |
| 5                      | Элэгдэл, эвдрэл            | - Зориулалтын бус замаар явснаар явган жим, зам гарах, хөрс дагтарших, талхлагдах<br>- Тээврийн хэрэгсэл шороон замаар зорчих | - Тархалтын хүрээ хязгаарлагдмал.<br>- Тархалтыг хязгаарлах боломжтой.<br>- Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой.<br>- Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөнө. |
| 6                      | Бохирдол                   | - Ахуйн, шингэн хог хаягдал<br>- Шатах тослох материал<br>- Бохир ус дамжуулах шугам хоолойн гэмтэл, доголдол                 | - Тархах хүрээ хязгаарлагдмал.<br>- Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана.                                                                           |
| <i>Ургамал бүрхэвч</i> |                            |                                                                                                                               |                                                                                                                                                                              |
| 7                      | Ургамлан нөмрөг талхлагдах | - Ашиглалтын талбай, барилга байгууламжийн орчим                                                                              | - Хэмжээ хязгаарлагдмал.<br>- Ургамалжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой.                                                                                               |
| 8                      | Хордох                     | - Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдал                                                                             | - Ургамлын биомасс багасна.<br>- Ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж болзошгүй.                                                                                               |
| <i>Амьтан</i>          |                            |                                                                                                                               |                                                                                                                                                                              |
| 9                      | Үргэн, дайжих              | - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн<br>- Дуу чимээ                                                                                | Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих                                                                                                                                  |
| 10                     | Хордох                     | - Хог хаягдал<br>- ШТМ асгаралт                                                                                               | - Тархалтын хүрээ хязгаарлагдмал<br>- Ашиггүй бичил биетэн үржих.                                                                                                            |

| <i>Нийгэм-эдийн засгийн орчин</i> |                                                                            |                                                     |                                                        |
|-----------------------------------|----------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------|--------------------------------------------------------|
| 11                                | Хөх морьтон - уран баримлын цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын цогцолбор | - Хүн амын эрүүл мэнд, ажил эрхлэх чадавх дээшилнэ. | Хүн амын эрүүл мэндэд эерэг нөлөө их.                  |
| 12                                | Үндсэн хөрөнгө                                                             | - Татварын эх үүсвэр                                | Улсын төсөвт хувь нэмэр оруулна.                       |
| 13                                | Шинэ ажиллагсад авна.                                                      | - Ажлын байр шинээр бий болно.                      | Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно. |

#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО

##### *Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго:*

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар Ш.Чимэддорж нь “Хөх морьтон - уран баримлын цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын цогцолбор” төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

Төслийг хэрэгжүүлэгч Ш.Чимэддорж нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОУАӨЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтад хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

##### **4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө**

Тус төлөвлөгөөний гол зорилго нь БОННУ-ний тайлангийн “Бүлэг 5”-т тодорхойлсон гол сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгахад оршино. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч Ш. Чимэддоржоос заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОУАӨЯ-аас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд буюу 2025 оноос 2029 оны хугацаанд төлөвлөв. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй. БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын дотор БОУАӨЯ-нд ирүүлж, мөн орон нутгийн засаг захиргааны байгууллага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, нутгийн оршин суугчдад танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

#### **4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Ш. Чимэддоржийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Хөх морьтон - уран баримлын цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын цогцолбор” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл “бага” эрчимтэй боловч үйл ажиллагаанаас гарах ахуйн шингэн хаягдал, хатуу хог хаягдлаас үзүүлэх нөлөөлөл, хөрс, ургамал, газрын доорх ус болон бусад хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

#### **4.1.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө**

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй болно.

#### **4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө**

Тус төслийн талбай нь Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг, Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд байрладаг. Төслийн талбай нь бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

#### **4.1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Төслийн талбайд түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

#### **4.1.5. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгалаа.


### **4.2. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Ш. Чимэддоржийн “Хөх морьтон - уран баримлын цэцэрлэгт хүрээлэн, аялал жуулчлалын цогцолбор” төсөл нь үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг



хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.



Зураг 6. Орчны хяналт шинжилгээ хийх цэгийн байршил

#### **Агаар орчин**

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

#### **Усны чанар**

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

#### **Хөрсөн бүрхэвч**

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд                                                                                                        | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ                                                                               | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ                      | Хэмжих нэгж | Тоо хэмжээ        | Нэгжийн үнэлгээ, төг | Нийт зардал (.төг) | Хэрэгжүүлэгч | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж                                                             | Биелэл-тийн шалгуур Баримтлах хууль журам, стандарт, аргачлал                                                             |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|-------------|-------------------|----------------------|--------------------|--------------|------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1                                                                                                                                           | 2                                                                                                                             | 3                                                  | 4           | 5                 | 6                    | 7                  | 8            | 9                                                                                        | 10                                                                                                                        |
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ                                                                      |                                                                                                                               |                                                    |             |                   |                      |                    |              |                                                                                          |                                                                                                                           |
| Тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч бохирдох, элэгдэх эвдрэх                                                                                     | Барилгын ажлын үед түүхий эд материалыг тээвэрлэхэд хучлага ашиглах                                                           | Агаарын чанар                                      | -           | -                 | -                    |                    | Ш.Чимэддорж  | Барилгын ажил дуустал                                                                    | Агаарын тухай хууль, Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр MNS ISO 4227:2002 MNS ISO 4226:2000 MNS 4585:2016 |
| Хийн хаягдал, тоосжилт                                                                                                                      | Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах | Агаарын чанар                                      | 2 цэгт      | ОХШХ-Т Тусгагдсан |                      | Ш.Чимэддорж        | Жилд 2 удаа  |                                                                                          |                                                                                                                           |
| Дуу чимээ                                                                                                                                   |                                                                                                                               |                                                    | 2 цэгт      |                   |                      |                    |              |                                                                                          |                                                                                                                           |
| Гадаргын болон газрын доорх ус нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ                                         |                                                                                                                               |                                                    |             |                   |                      |                    |              |                                                                                          |                                                                                                                           |
| Ус ашиглалт                                                                                                                                 | Төсөл хэрэгжүүлэгч нь Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журмыг мөрдөж тус журмын дагуу тоолуур суурилуулах                 | Усны нөөц хэмнэх                                   | Иж бүрэн    | 300.000           |                      | Ш.Чимэддорж        | Нэг удаа     | Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам, Усны тухай хууль,                            |                                                                                                                           |
|                                                                                                                                             | Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах зөвлөмж                                                                                       |                                                    | -           |                   | Ш.Чимэддорж          | Жил бүр            |              |                                                                                          |                                                                                                                           |
| Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ                                                    |                                                                                                                               |                                                    |             |                   |                      |                    |              |                                                                                          |                                                                                                                           |
| Хөрс, ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох                                                                                   | Барилгын явцад үржил шимт хөрсийг хадгалах, хамгаалах ажлыг NS 5916:2008 стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгүүлэх         | Хөрсөн бүрхэвч                                     | 500.000     |                   |                      | Ш.Чимэддорж        | Нэг удаа     | MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт |                                                                                                                           |
| Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ |                                                                                                                               |                                                    |             |                   |                      |                    |              |                                                                                          |                                                                                                                           |
| БОННУ-ний тайлангийн БОМТ-ны хэрэгжилтийн талаар нутгийн иргэдэд тайлагнах                                                                  |                                                                                                                               | Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд | багц        | -                 | -                    | -                  | Ш.Чимэддорж  | ИНХ-ын дарга                                                                             | БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам                                                           |
| Нийт                                                                                                                                        |                                                                                                                               |                                                    |             |                   | 800.000              |                    |              |                                                                                          |                                                                                                                           |

## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт                                | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ                                      | Арга хэмжээний цар хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт                                                                                                                                                                                           |
|--------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|--------------------------|-------------|------------|---------------------|------------------|--------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох | Орчны тохижилтыг сайжруулан төслийн талбайд ногоон байгууламж хийх | Гүйс                     | Ширхэг      | 10         | 8000                | 80.000           | Төсөл хэрэгжих хугацаанд       | - Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт<br>- MNS5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт.MNS5916:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. |
|                                                                          |                                                                    | Гацуур                   | Ширхэг      | 5          | 45.000              | 225.000          |                                |                                                                                                                                                                                                                     |
